

БОНХЯ, ТХНУГ, “ДОРНОД” ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА



**ДОРНОД МОНГОЛЫН ТАЛ ХЭЭРИЙН ЦАГААН
ЗЭЭРИЙН ТОО ТОЛГОЙН СУДАЛГААНЫ
АЖЛЫН ТАЙЛАН**

**Дорнод аймаг
2012 он**

ДОРНОД МОНГОЛЫН ТАЛ ХЭЭРИЙН ЦАГААН ЗЭЭРИЙН ТОО ТОЛГОЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2012.10.28

Хэрлэн сум

ХУРААНГУЙ

Цагаан зээр нь Ази тивд нүүдэллэн амьдардаг том биетэй хөхтөн амьтны томоохон популяцийн нэгэн төлөөлөгч юм. Өнгөрсөн хагас зууны турш энэ зүйл амьтны тархац нутаг маш их эрчимтэй хумигдаж, мөн Дорнод монголын тал хээрт тоо хэмжээ багасах нь ажиглагдах боллоо.

Цагаан зээр нь Дагуурын ойт хээр, Монгол–Манжуурын хялганат хээрийн эко-бүсийн унаган зүйл бөгөөд хялганат хээрт экологийн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Цагаан зээрийн популяцийн өсөлт, бууралт, нүүдлийн замналыг тогтоох, тоо толгойг гаргах зорилгоор Монгол Дагуур, Дорнод Монголын ДЦГ, түүний орчны бүс нутгуудаар шугаман трансектын аргаар судалгааг 2012 оны 10 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 20 хүртэл нийт 20 хоногийн хугацаанд ДХЗ-ны судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагчид хийж гүйцэтгэлээ.

Шугаман трансектийн аргаар нийт 132 цэгт ажиглалт явуулж, нийт 122 500 тоо толгой цагаан зээр тоологдсон. Мөн шугаман трансектийн судалгааны маршрутын урт 252-оос 1,356 км-ийн хооронд хэлбэлзэж байлаа. Судалгааны замд 1-2000 хүртэл тооны зээр тааралдаж байсан бөгөөд нэг сүрэг дэх зээрийн дундаж тоо 01 ± 221 -ээс 315 ± 2000 -ийн хооронд хэлбэлзэж байлаа.

Түүвэрлэн авсан дээжийн хэлбэлзлийг тооцож үзэхэд зээрийн сүргийн хэмжээ 60-аас 174-ийн хооронд байлаа.

Бага хэмжээний сүрэг нь нийт ажиглагдсан сүргийн ойролцоогоор 75 хувь болж байсан бөгөөд харин нийт тоологдсон зээрийн 80-95 хувь нь том сүрэг харъяалагдаж байсан юм.

Түүнчлэн зээрийн нягтшлийг тооцож үзэхэд 1 км^2 газарт 8,98-15,81 зээр оногдож байлаа.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ:


Цагаан зээрийг Дорнод Монголын тал нутагт гурван гол полуляци Чойбалсан хотоос хойно, баруун өмнө, зүүн өмнөдөд хуваагдсан гэж үздэг.

Тус судалгааг:

- Хэрлэн голын хойд хэсэг Хавирга, Цагаан нуур, Хөх нуур, Дөч, Улз голын сав газар, Хөх уул орчим, Угтам, Яхь нуур, Тосон-Хулстайн БНГ-ууд



- Хэрлэн голоос урагш, Мэнэн, Сангийн далай, Лаг, Матад, Жаран тогоон зэрэг газруудад тархсан зээрийн полуляцийн талбарт төвлөрүүлэн тус тус гүйцэтгэлээ.



Судалгааны шугаман трансектын бүдүүвч зураг.

Судалгааны талбарыг тус бүр 60 км-ийн өргөнтэй, янз бүрийн хэмжээний урттай хийсэн. Хэсэг бүрийн төв хэсгээр хойноос урагшаа чиглэлтэй маршрут/трансектийн дагуу явж судалгааг хийв.

Хэдийгээр маршрут/трансектийг байрлал маань өөрчлөлтгүй нэг газартаа байсан боловч, судалгааг тэрхүү трансектээс байнга эхлүүлж байсангүй, мөн түүнчлэн зөвхөн нэг тийшээ чиглэлтэй явж байсангүй.

Судалгаа нэг бүрийн эхний маршрут/трансектийг эхлүүлэхдээ хаана, хэзээ хүрэх вэ гэдгээ тооцсоны үндсэн дээр тогтоож байсан.

Мөн байршил тодорхойлох систем /GARMEN-GPS 12/, Монголд зориулж боловсруулсан компьютерийн GPS газрын зургийн программыг ашиглан хэсэг тус бүрийн төв шугамыг аль болохоор барьж байлаа. (тухайн газар нутагт хашаа, барилга байгууламж, гол горхи цөөхөн газар, хадан цохио, элсэн манхныг тойрох зорилгоор трансект буюу маршрутаас гажиж байсан)

Маршрутаар явж байх үед, цагаан зээр үзэгдсэн тохиолдолд машинаа зогсоож телескоп, жирийн дурангийн тусламжтайгаар хэдэн зээр байгааг, зээр биднийг ажиглаж зугтаж алга болохоос өмнө тоолох оролдлого хийж байв.



Нэг ижил хэв загвартай орон зайд аргачлалын дагуу ажиглалтын цэгээс объект хүртэлх зайг хэмжих зорилгоор гар ажиллагаа бүхий дүрсийн зайг давхар тодорхойлогчийг ашигласан ба луужингийн бичиглэлийг 2,5 градусын нарийвчлалтайгаар тэмдэглэж явлаа. Манай машиныг анхны зогсож байсан газраасаа хөдлөх үед, зээрийн сүргийн анх зогсож байсан газрын төв хэсэг буюу тэр орчимд байх байгалийн цэг-бут, ялгарах өвс ургамлыг санаандаа тэмдэглэн авсны дараа ажиглалт, бичлэгээ хийж байлаа.

Бидний ажигласан зээрийн сүрэг анхлан машины байршилтай перпендикуляр байрлалд тааралдсан тохиолдолд зай тодорхойлогч маань ажиллах чадваргүй болж байсныг ажигласан бөгөөд энэ тохиолдолд маршрутаа орхиж зээр ажиглагдсан уг газарт очиж GPS-ийн зайг авах буюу эсвэл бусад ажиглагч нартайгаа зөвлөлдсөний эцэст зайг тооцоолон гаргаж байв.

Хэрвээ зээрийн сүрэг машины эгц өмнө анхлан тааралдвал зээр анх харагдсан газар очиж байгаад маршрутын голын шугамаас перпендикуляр зайг хэмжиж байв.

Судалгааны сүүлийн хэсэгт хийж гүйцэтгэсэн зээрийн улирлын нүүдэл шилжилт, хөдөлгөөн, амьдрах орчны чанарын судалгаанд ч GPS-ийн заалтын бичиглэл хийж авч байсан.

Судалгааны аялалын үеэр машины хурдыг жигд 25-35 км/цагт барьж, бүтэн өдөржингөө явахыг хичээж байсан болно. Судалгааг ихэвчлэн өглөөний 7 цагаас эхлэж алсын бараа сайн харагдахаа больсон оройн 17 цагаар дуусгаж, хоногт 200-240 км зам туулж байлаа. Сүрэгт байгаа зээрийн тоо толгойг аль боломжоороо нарийвчлал сайтай тоолохыг хичээж байлаа. Хэрэв сүрэг зээрийг олж харсан дор мөнөөх зээрийн сүрэг маань биднээс зугтаж байгаа тохиолдолд, эсвэл тэгш тал газар хэдэн арваараа зэрэглэн зогсож байгаа тохиолдолд сүргийг 5-аар нь, 10-аар нь, 25-аар нь, 50-иар нь гэх мэтээр тоолж байлаа. Цаг хугацаа хангалттай байгаа нөхцөлд тооллогын нарийвчлалыг бататгах зорилгоор дахин тооллого хийж байлаа.



МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шугаман трансектийн аргаар дээжлэн хэмжих нь Зээрийн нягтшлийг тодорхойлохдоо эхний үед энгийн зурвас трансектийн тооцоог ашиглаж байв. Энэ аргаар бодохдоо зурвас газар байх амьдтыг 100% ажиглагдсан гэж үздэг нь зарим нэгэн тохиолдолд тухайлбал, тал нутагт байгаа цагаан зээрийн хувьд бодит биш таамаг юм.

Нягтшлийг тодорхойлоход трансектийн өргөний үзүүлэх нөлөөг тодорхойлох зорилгоор, жил жилийн судалгааны нийт маршрутын/трансектийн уртыг янз бүрийн урттай зурвас газрын өргөнөөр үржүүлж судалгааны нийт талбарыг тодорхойлж байлаа.



Эдгээр зурвас газрын өргөний хэмжигдэхүүн хоёр тохиолдолд өмнө нь тогтоосон зай-400 м (трансектийн гол шугамаас хоёр тийшээ тус бүр 200 м гэсэн үг); 1000 м (трансектийн гол шугамаас хоёр тийшээ тус бүр 500 м гэсэн үг) байсан болно.

Бас дахин өөр хоёр трансектийн өргөний хэмжигдэхүүнийг судалгаа хийх явцдаа цуглуулсан, зээр ажиглагдсан зайны тоон мэдээллүүдийн пропорци байдлаар тодорхойлов.

Эхнийх нь тэмдэглэсэн зайнуудын 85%-ийг хамруулсан хамгийн ойрын зайг хоёроор үржүүлж авсан хэмжээс, харин хоёр дахь нь зээр ажиглагдсан хамгийн холын зайг мөн хоёроор үржүүлж авсан хэмжээс болно.

Судалгааны нийт талбайг бодож гаргасны дараа, нийт ажиглагдсан зээрийн тоог тухайн зурвас газрын талбайд хувааж зээрийн нягтшлийг бодож гаргасан. Энэ нягтшлийн хэмжээг нийт судалгааны талбайн нутаг дэвсгэрт экстраполяцийн аргаар шилжүүлж сүргийн нийт тоо толгойг гаргасан болно.



Зүйлийн том популяци буюу түүний нэг хэсэг бодгаль нь махчин амьтдын идэш золиос бологч зүйл болохын хамт хялганат хээрийн ургамлын бүлгэмдлийн олон янз байдлыг бүрдүүлэх, хадгалах, сэргээхэд энэхүү нүүдлийн туруутан чухал үүрэг гүйцэтгэдэг.

ҮР ДҮН

Судалгааны тоо баримт:

Хээрийн судалгааны ажлыг 2012 оны 10 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 20 хүртэл нийт 20 хоногийн хугацаанд 3850км зам туулж гүйцэтгэлээ. Судалгааны ажлын турш 110-174 сүргийн 10-122500 зээрийг ажигласан.



Шугаман трансектийн судалгааны маршрутын урт 252-оос 1,356 км-ийн хооронд хэлбэлзэж байлаа. Судалгааны замд 1-2000 хүртэл тооны зээр


тааралдаж байсан бөгөөд нэг сүрэг дэх зээрийн дундаж тоо 01±221-ээс 315±2000-ийн хооронд хэлбэлзэж байлаа. /Хүснэгт 1-ээс үз/

Хүснэгт 1.

№	Газрын нэр	огноо	Сүргийн тоо	Сүргийн дундаж хэмжээ	Зээрийн нийт тоо
1	Мэнэнгийн тал	2012.10.01	174	161±442	4985
2	Вангийн цагаан уул	2012.10.03	185	138±303	9350
3	Сангийн далай	2012.10.04	92	85±110	4200
4	Лагийн хоолой	2012.10.06	140	121±315	8230
5	Усан хөл	2012.10.07	12	96±121	3118
6	Цагаан тэмээт	2012.10.01	52	45±82	8500
7	Эхэн худаг	2012.10.03	210	84±180	10420
8	Жаран тогоо	2012.10.04	350	54±146	12850
9	Хавирга	2012.10.06	41	31±95	3847
10	Хар, цагаан нуур	2012.10.07	21	10±114	1541
11	Хөх нуурын хөндий	2012.10.01	135	54±122	6499
12	Цагаан чулуут	2012.10.03	2	1±12	18
13	Үүлэн хан	2012.10.04	10	1±84	526
14	Хөх уул	2012.10.06	95	28±107	10240
15	Дөч, Улз голын	2012.10.07	125	46±117	4673
16	Угтам уул	2012.10.01	31	20±171	2311
17	Дун уул	2012.10.03	218	25±1800	11478
18	Барьхин уул	2012.10.04	142	18±2150	10724
19	Дайхарын рашаан	2012.10.06	180	71±168	8441
20	Тосонгийн нуур	2012.10.07	9	34±88	549
Дундаж тоо			110±174	315±2000	122 500

Түүвэрлэн авсан дээжийн хэлбэлзлийг тооцож үзэхэд зээрийн сүргийн хэмжээ 60-аас 134-ийн хооронд байлаа.

Бага хэмжээний сүрэг нийт ажиглагдсан сүргийн ойролцоогоор 75 хувь болж байсан бөгөөд харин нийт тоологдсон зээрийн 80-95 хувь нь том сүрэг харьяалагдаж байсан юм. Түүнчлэн зээрийн нягтшлийг тооцож үзэхэд 1км² газарт 8,98-15,81 зээр оногдож байлаа.



Энэхүү томоохон хэмжээний судалгааны ажлыг Хамгаалалтын захиргааны мэргэжилтнүүд, байгаль хамгаалагч нар бие даан хийж гүйцэтгэсэн нь тэдний судалгааны ажлын арга зүй, чадавхийг тодорхой хэмжээгээр дээшлүүлсэн.

Мөн бусад судлаач нарын хийсэн цагаан зээрийн судалгааны тайлангийн ажилтай харьцуулан дүн шинжилгээ хийхэд тухайн зүйлийн өсөлт, бууралтыг авч үзэхэд ТХГН-уудад өссөн, бусад тархац нутгуудад буурсан дүн гарч байна.

ДҮГНЭЛТ

Өргөн тархацтай нутагт амьдардаг тоо толгойн хувьд хорогдож байгаа цагаан зээрийн өнөөгийн популяцийн хувьд үр дүнтэй хамгааллыг дан ганц ТХГН хангаж чадахгүй.

Иймд ландшафтын үр дүнтэй холбоос өөрөөр хэлбэл түүний маш өргөн уудам нутагт ямар ч хязгаарлалтгүй шилжин нүүдэллэдэг газар нутгийн хэмжээнд хамгааллыг бий болгох ёстой.

Зээр нь идээших бэлчээр нутгаа байнга өөрчилж, бэлчээрийн ургац, гарцыг даган жил бүр өөр өөр нутагт нүүдэллэн шилжилт хөдөлгөөнөө хийдэг.

Бэлчээрийн гарц, өвс тэжээлийн олдоцыг даган нүүдэллэн явдаг энэ туруутан амьтан амьдрах орчны хуваагдал, агналтанд өртөх, гэрийн малтай бэлчээрийн өрсөлдөөнд орох, өвчин зэрэг олон асуудлуудад өртдөг.

Өнөөгийн болон ирээдүйд төлөвлөж байгаа хөгжлийн асуудлууд тухайлбал зам тээврийн дэд бүтэц, төмөр зам барих, уул уурхай, газрын тосны ашиглалт

хайгуул эрчимжиж байгаа нь зээрийн амьдрах орчинд маш ноцтой аюулыг дагуулж байна. Зээрийн шилжилт хөдөлгөөн, амьдрах орчны ашиглалтанд малчдын суурьшил бас нөлөө үзүүлж байна.

Хуурайшилт болон түймрийн нөлөөнөөс шалтгаалан ургамлын зүйлийн бүрдэл өөрчлөгдөж цагаан зээрийн амьдрах орчин багасах, идэш тэжээлийн хомсдол үүсэх, тархац нутгийн хэмжээ хумигдах болсноор хойшоо чиглэлтэй (ОХУ-руу) нүүдлэх нь байдал энэхүү судалгаагаар ажиглагдсан.

АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. Лхагвасүрэн Б. Milner-Gulland E.J. The Status and Management of the Mongolian Gazelle (Монголын цагаан зээрийн популяцийн өнөөгийн байдал, менежмент) 1997.
2. Луцкекина А.А Эколого-географические основы охраны и рационального использования дзерены в МНР. (Монгол орны цагаан зээрийг хамгаалах экологи-газар зүйн үндэс, тэдгээрийг зүй зохистой ашиглах нь). өөрийн бүтээл. Биологийн ШУ-ны дэд докторын зэрэг хамгаалсан диссертаци, 1990 он
3. Ариунгэрэл.Д, 1995. Дорнод Монголын экосистемийн өөрчлөлт тайлан. Чойбалсан хот.
4. Бадарч.Н, Цэгмид.Ш, Цэрэнсодном. Ж, 1997. “Монгол орны дорнод хэсгийн ландшафт ба байгалийн мужууд” УБ.
5. Банников.А.Г, Скалон. М.Н, 1948. Орнитологические заметки о Монголии. Журн. Охрана природы. № 5 с 17-31. Москва
6. Батцэрэн. Г, 1973. Монголын дорнод хэсгийн хөрсөн дэх зэс. Химийн хүрээлэн. Эрдэм шинжилгээний бүтээл. №11
7. Боркин.Л.Я, Воробьева.Л.Я, Дареский Э.И, 1988. Земноводные и пресмыкающиеся МНР (Земноводные). Москва
8. Грубов В.М, 1982. Определитель сосудистых растений Монголии. Москва
9. Дашдэлэг Н., Бат Б. 1972. Монгол орны гол мөрөн.
10. Дашням. Б, 1980. Дорнод Монголын ургамлын аймаг, ургамалшил. УБ.
11. Дорнод аймгийн уур амьсгалын эмхэтгэл. УБ. 1988 он
12. Дорнод хамгаалалтын захиргааны 1993-1998 оны тайлангууд. Дорнод хамгаалалтын захиргаанд.
13. Доржготов. Д, 1976. Монгол орны хөрс-газар зүйн мужлалт. УБ
14. Дуламцэрэн. С, 1993. Монгол орны хөхтөн амьтны зүйл, хам бүрдлийг хамгаалах асуудал. УБ.
15. Дуламцэрэн С., Цэнджав Д., Авирмэд Д. 1989. БНМАУ-ын амьтны аймаг хөхтөн амьтан. II боть. Улаанбаатар.
16. Жамсраны Цэвээн, 1927. ”БНМАУ-ын газар орны байдал”. УБ. 27 тал
17. Кейти Шарп, С. Энхболд, 2002 он “Дорнод аймгийн ан агнуур” судалгааны ажлын тайлан
18. Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр. УБ. 1997

19. Мөнхбаяр.С, Бямбасүрэн А., Ариунгэрэл. Д, 1997..Дорнод Монголын ДЦГ-ын ургамлын жагсаалт. Дорнод Монголын ДЦГ-т ажилласан тайлан. 1:100000 газрын зураг
20. Өлзий хутаг. Н, 1989. Монгол орны ургамлын аймгийн тойм. УБ
21. Рийдинг,Р.П.,Сумъяа,Д.,Самъяа,Р.,Батсайхан,Н., 1994. Монголын сээр нуруутан амьтдын нэрсийн толь бичиг. УБ. 104х.
22. Соколов В.Е, Болд.А, Дулмаа. А., 1983. Рыбы Монгольской Народной Республики Москва.
23. Үндэсний атлас, 1990. Монгол улсын ШУА, ЗХУ-ын ШУА, Улаанбаатар, Москва